

ЭДИЙН ЗАСАГ

**БНСУ-ЫН ХӨГЖЛИЙН ЗАРИМ  
ОНЦЛОГ, «ШИНЭЭР  
ҮЙЛДВЭРЖСЭН ОРНУУД»-АД  
ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ**

**Б. Лхагваа**

1960 он хүртэл ихээхэн сул дорой хөгжилтэй орнуудын нэг байсан Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ) шинээр үйлдвэржсэн 9 орны (ШҮО) тэргүүлэх цуваанд орсноор үл барам эдийн засгийн хөгжлийн зарим үзүүлэлтээрээ хөгжингүй капиталист орнуудын түвшинд хүрээд байна. Энэ нь тус орны сүүлийн 30 жилийн эрчимтэй хөгжлийн дүнд бий болсон эдийн засгийн өндөр хүчин чадал; олон улсын хөдөлмөрийн хуваарьт оролцож буй гүнзгий оролцоо, бүс нутгийн хийгээд дэлхийн капиталист аж ахуйд эзэлж буй идэвхтэй байр сууриар тодорхойлогдоно.

Сүүлийн 25 жилд үндэсний нийт бүтээгдэхүүнийх нь (98,1 млрд. доллар) үйлдвэрлэлийн жилийн дундаж өсөлт 8,5 хувь,<sup>1</sup> түүнд эзлэх экспортын хувийн жин 42,5 хувь<sup>2</sup> хүрч энэ талаар дэлхийд XI байранд орж улмаар 2000 он гэхэд технологийн илүү өндөр хөгжилтэй дэлхийн 10 орны эгнээнд багтах боломжтой болжээ. Мөн 1992 онд эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагад элсэхээр тус улсын засгийн газар төлөвлөж байна.

БНСУ цулгүй хоосноос ийм үсрэлт хийсэнгүй. Газар тариалан, аж үйлдвэрийн салбарт уг дэвшлийн хөрс суурь болсон түүхэн урьдчилсан нөхцөлүүд 1950-иад он хүртэл ямар нэг хэмжээгээр бүрдсэн байв.

Улс орноо ийнхүү богино хугацаанд үйлдвэржүүлсэн явц нь шинээр үйлдвэржсэн бусад орны нэгэн адил дараахь гурван үе шатыг дамжсан байна. Үүнд: **Эхний шатанд**, импортын бүтээгдэхүүнийг аль болохоор дотооддоо үйлдвэрлэх бодлого явуулж хэрэгжүүлжээ. Эл зорилгоор 1962—1966 оны анхдугаар таван жилийн төлөвлөгөөнд аж ахуйн ийм салбаруудыг түлхүү хөгжүүлэх, үүнтэй уялдуулан үйлдвэрлэлийн дэд бүтцээ өөрчлөх, ажиллах хүчийг нэмэгдүүлэх, эрдэс түүхий эд их хэмжээгээр гаргахыг хязгаарлах, үндэсний болон гадаадын хөрөнгө оруулалтын үндсэн хэсгийг энэ салбарт зориулах зэрэгт гол анхаарлаа төвлөрүүлсэн байна. Эдгээр асуудлыг шийдвэрлэсний дүнд гаднаас оруулдаг бүтээгдэхүүнийг өөртөө үйлдвэрлэх явдал аажим аажмаар нэмэгдэн улмаар зонхилох шинжтэй болжээ. Үүний хажуугаар үндэсний хөрөнгөлөг хэсгүүд экспортын чиглэлээр хөнгөн үйлдвэрүүд хөгжүүлж ирсэн байна.

**Хоёрдахь шатанд**, экспортын хүчин чадлыг нэмэгдүүлж, эдийн засгийн суурь салбаруудыг хөгжүүлэхэд анхаарал тавьжээ. 1967-1971 оны таван жилийн төлөвлөгөөнөөс эхэлж 1970-аад оны сүүлч хүртэл үргэлжилсэн энэ үеийн үндсэн зорилт нь эхний шатанд авсан арга хэмжээгээ бататгангаа экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн төмөрлөг, хими, машины үйлдвэрлэлийг өсгөн нэмэгдүүлэх явдал байжээ. Эдгээр гол зорилтыг хэрэгжүүлснээр эдийн засагт экспортын чиглэлийн үйлдвэрлэл голлон импортын бүтээгдэхүүний үйдвэрлэлийг түүнд дагалдуулан хослуулах өөрчлөлт хийж чадсан байна.

**Гуравдахь шатанд.** Оюуны багтаамж бүхий үйлдвэрлэлийн салбарыг 1980-аад оноос илүү хурдацтай хөгжүүлж эхэлсэн байна. Хамгийн товчоор тоймлон үзэхэд энэ бүх шатны явцад үндэстэн дамнасан корпорацууд болон гадаадын хөрөнгийг их хэмжээгээр оруулсан; хөдөлмөр, хөрөнгийг төвлөрүүлсэн, аж ахуйн салбаруудынхаа дэд бүтцийг өөрчилж хөдөлмөрийн бүтээмжийн өсөлтийг тогтвортой хангасан; шинэхэн техник технологийг өргөн нэвтрүүлсэн зэрэг эдийн засгийн гол гол арга хэлбэрийг ашигласан байдал харагдаж байна.

Азийн ШҮО-нууд 1980—1985 онд 44 млрд. долларын зээл авсаны 51 хувь, Ази, Номхон далайн орнуудад Японы хөрөнгө оруулалтын 51,6 хувь (1 байр), АНУ-ын 28,6 хувь (П байр) БНСУ-д ноогдож буй нь ШҮО-нуудын дотор гадаадын хөрөнгө оруулалтыг хамгийн их авсан орон болж байна. Мөн тусламжийн хэлбэрээр багагүй хөрөнгө оруулжээ. Онцлог нь гадаадын хөрөнгө оруулалтыг үндэсний эдийн засгийн өвөрмөц байдалдаа тохируулан шаардлагатай салбарт туйлын өгөөжтэй ашиглаж чаджээ.

Улс орныхоо эдийн засгийг богино хугацаанд хөгжүүлэхэд нөлөөлсөн өөр нэг чухал хүчин зүйл бол нийгмийн сэтгэл зүйн бэлтгэл зайлшгүй мөн болох нь БНСУ-ын хөгжлийн замналаас харагдаж байна. Ийм сэтгэл зүйн бэлтгэлийг төлөвшүүлэхэд чиглэсэн улс төр, үзэл суртал, эдийн засгийн бодлогыг эх оронч, үндэсний уламжлал, бахархалтай зөв хослуулан тууштай явуулж, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, нөхцөлүүд ялангуяа хувиарлалтын оновчтой арга барилыг бүрдүүлэхэд онцгой анхаарал тавьж иржээ. «Ажилсаг зөгий» буюу «ажлын чөтгөр» хэмээгдэн дэлхийд нэрлэгддэг японы ажилчид 1985 онд (30 үйлдвэрийн газрын судалгаагаар сард 21,8 өдөр ажиллахдаа 175,8 цаг (илүү ажилласан цаг 14,8) ажилласан бол БНСУ-ын 10 үйлдвэрийн газарт хийсэн судалгаагаар солонгос ажилчид сард 24,8 өдөр ажиллахдаа 225,5 цаг (илүү ажилласан цаг 32,8) ажиллажээ.<sup>4</sup>

Дээр дурдсан аргуудыг уян хатан байдлаар хэрэгжүүлсний дүнд боловсруулах үйлдвэр, аж ахуйн тэргүүлэх салбар болж экспортын 91,9 хувийг эзлэхэд хүрсэн байна.

Жижиг, дунд үйлдвэрүүдийг хөгжүүлэхийн зэрэгцээгээр үйлдвэрлэл, хөрөнгийг төвлөрүүлснээр үндэсний томоохон хөрөнгөлөг нэгдлүүд үүсч хөгжсөн байна. 1961 онд 140 гаруй томоохон үйлдвэрүүд байсан бол 1984 онд тэдгээрийн тоо 1128-д хүрч тус бүр нь 1000-аад ажилчинтай болжээ. Эдгээр үндэсний хөрөнгөлөг нэгдлүүд зөвхөн дотооддоо төдийгүй дэлхийн капиталист аж ахуйд мэдэгдэхүйц үүрэг гүйцэтгэж буй бөгөөд хөгжиж буй орнуудын ийм үүрэгтэй 600 томоохон нэгдлийн гуравны нэг орчим нь Азийн ШҮО-нуудад түүний 100 гаруй нь БНСУ-ынх аж. Томоохон нэгдлүүдийн хүрээний тэлэлт нь банкны оролцоог өргөжүүлэн санхүү-үйлдвэрийн бие даасан бүлэглэлүүд үүсгэн тэдгээр нь 1980-аад онд улам идэвхжих хандлагатай болсныг 1955 онд тавхан банкаар эхлэл нь тавигдсан ийм шинжтэй бүлэглэлүүд 1988 онд 100-д хүрч тэдгээрт 1983 онд 400, 1988 онд 820 пүүс, нэгдэл хамрагдсан баримт харуулж байна.

Эдгээр бүлэглэлүүдэд дулдуйдан БНСУ-ын засгийн газар японы жишээгээр 13 томоохон худалдаа-үйлчилгээний иж бүрэн пүүсүүд байгуулсан бөгөөд үндэсний иймэрхүү төрөлжсөн буюу иж бүрэн санхүү-үйлдвэр, худалдаа-үйлчилгээний нэгдэл, бүлэглэлүүд гадаадад үйлдвэрлэлийн хөрөнгө гаргах эрмэлзэл алхам, алхмаар нэмэгдэж эхэлжээ. 1989 оны эхэнд БНСУ 50 гаруй оронтой 1,2 млрд. долларын хөрөнгө оруулалтын 500-гаад төсөл байгуулж, хэмжээ, газар зүйн

хүрээгээрээ Азийн ШҮО-нууд дотор тэргүүлэх байранд явж байна. Хөрөнгө гаргалтын 32,5 хувь Америк тив, 12,5 хувь Латин Америк, 41 хувь Зүүн өмнөд Ази, Номхон далайн сав нутагт, 7,4 хувь Ойрхи, Дундад дорнод, 4,2 хувь Африк тив, 2,4 хувь Өрнөд Европт<sup>5</sup> ноогдож буй бөгөөд энэ ажлыг «Чобел», «Деву», «Самсунг», «Хёнде», «Лаккиголдстар», «Хесонг» зэрэг худалдаа-үйлдвэрийн 200 гаруй томоохон пүүс, нэгдлүүд үндсэнд нь гүйцэтгэж байна. Үйлдвэрлэлийн хөрөнгийн голыг барилга байгууламжийн салбарт зориулж эдүгээ өөрийн техник, технологи, ажиллах хүчийг ашиглан тус улсын 60 гаруй пүүс дэлхийн 30 гаруй оронд үйлдвэр, иргэний барилга байгууламж барьж буйн сацуу мод боловсруулах, загас агнуур, тээвэр худалдааны объектуудын чиглэлээр мөн хөрөнгө гаргаж байна.

БНСУ-ын гадаад эдийн засгийн харилцааны өөр нэг хэлбэр нь гадаад худалдаа юм. Экспортын хэмжээгээр (1986 онд 34,7 млрд. доллар) Азийн ШҮО-нууд дотор Тайвань, Гонконгийн дараа орж дэлхийн 20 том бараа нийлүүлэгчдэд багтаж байна.

Гадаад зах зээл дэх байр сууриа бэхжүүлэх, гадаадын хөрөнгө, Үндэстэн дамнасан корпорацын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Экспорт-Үйлдвэрлэлийн Бүс (ЭҮБ) байгуулахад тус улс шинээр үйлдвэржсэн бусад орноос илүү идэвхтэй оролцож тэр чанараараа экспортын нийт орлогын 20 гаруй хувийг энэ бүсээс олж байна. ЭҮБ бол сүлжмэл бөс бараа, гутал, хувцас, цахилгаан бараа зэрэг өргөн хэрэглээний түүнчлэн электрон техник, автомашин, суурь машин, аж үйлдвэрийн бусад салбарын зориулалттай бүтээгдэхүүн экспортлох дэлхийн шинэ төв болоод байна.

БНСУ хөлөг онгоцны үйлдвэрлэлээр дэлхийд Японы дараа, телевиз гаргалтаар (1986 онд 11,3 сая ширхэг) хөрөнгөтөн орнууд дотор эхний байр эзэлж буй бөгөөд 1990 онд суудлын автомашин 2 саяыг экспортлох, сансрын пуужин хөөргөх бэлтгэл хийж буй ажээ.

Мөн азийн ШҮО-нууд нэлээд ирээдүйтэй яваа цахилгаан хэрэгсэл, электрон техникийн үйлдвэрлэлээр удаалж, ахуйн хэрэгцээний цахилгаан хэрэгслээр эхний, Швейцарын эрдэм шинжилгээний байгууллагын аргачлалаар (340 үзүүлэлтээр) гаргасан өрсөлдөх чадвараар Франц, Итали, Испани, Португали, Малайзаас дээгүүр, азийн ШҮО-нуудаас Гонконг, Сингапур, Тайваний дараа 18, хөдөлмөрийн бүтээмжийн өсөлтөөр (1970—1986 онд) азийн ШҮО-нууд дотор тэргүүн байранд байна. Хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт ийм өндөр түвшинд хүрэхэд хамгийн сүүлийн үеийн техник, технологи ашигласан үйлдвэрлэлийн автоматжуулалт өндөр түвшинд хүрсэн, нарийн мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан, үйлдвэрлэлийг хөтлөн удирдах оновчтой аргуудыг ашигласан, шинжлэх ухаан-техникийн ололтыг үр өгөөжтэй ашиглах суурь баазтай болсон зэрэг хүчин зүйл нөлөөлжээ. Энэ нь дотоодын хэрэгцээг хангах боловсруулах үйлдвэрлэлээс экспортын үйлдвэрлэл давамгайлах чиглэл рүү 1980-аад онд шилжихэд чухал үүрэг гүйцэтгэсэн байна.

Хөгжиж буй орнуудтай ШҮО-нууд түүний дотор БНСУ-ын хамтын ажиллагаа өргөжих төлөвтэй байна. Гадаад худалдааг голлосон хамтын ажиллагааны уламжлалт хэлбэрээ худалдаа-үйлдвэрийн эздийн хөрөнгийг оруулах, техник технологи нийлүүлэх, эдийн засаг, санхүүгийн тусламж үзүүлэх, шинжлэх ухаан, техникийн талаар хамтран ажиллах зэргээр баяжуулах болов. ШҮО-нууд болон хөгжиж буй орнуудын гадаад худалдааны бараа гүйлгээний эргэлт 1970—1985 онд 13 дахин өсч нийтдээ 92,3 млрд. долларт хүрч ШҮО-нуудын гадаад худалдаанд хөгжиж буй орнуудын эзлэх хувь 20-25 хувь болж

байна БНСУ энэ талаар Сингапурын дараа хоёр дахь байранд явна (14 млрд. доллар, үүнээс экспорт 7,5 млрд. доллар)<sup>6</sup> ШҮО-нуудын пүүсүүд хөгжиж буй орнуудын эдийн засгийн боловсруулах, олборлох үйлдвэр, барилга, худалдаа үйлчилгээний хүрээнд 15 млрд. долларын хөрөнгө оруулсан бөгөөд дээр дурдсан шинэ хэлбэрүүдээс худалдаа-үйлдвэрийн эздийн хөрөнгө оруулалт сүүлийн жилүүдэд мэдэгдэхүйц идэвхжиж зарим талаар хөгжингүй капиталист орнуудтай өрсөлдөх болов. Ялангуяа ажиллах хүч хямдтай орнуудад хувцас, сүлжмэл эдлэл, гутал (капиталист орнуудын экспортод БНСУ гутал, хувцас гаргалтаар Ш, сүлжмэл эдлэлээр V байранд яваа), цахилгаан хэрэгсэл, электрон техникийн үйлдвэрүүд байгуулахад хөрөнгө оруулж байна. БНСУ АСЕАН-ы орнуудад аж үйлдвэрийн болон бусад салбарт 240 гаруй объект барихад оролцсоны дээр 1988 онд Зүүн өмнөд Ази, Өмнөд, Умард Америкт гутал, сүлжмэл эдлэлийн 10 орчим, Энэтхэг, Мексик, Тайландад цахилгаан хэрэгслийн үйлдвэр байгуулжээ. Усан цахилгаан станц, зочид буудал, иргэний болон албаны барилга, автомашин, төмөр зам зэрэг барилга байгууламжийн томоохон төсөл хэрэгжүүлэх талаар БНСУ, Бразиль хоёр ШҮО-нууд дотор гол үүрэг гүйцэтгэж байна.

Хамтын ажиллагааны бас нэг томоохон шинэ хэлбэр-санхүү эдийн засгийн тусламж үзүүлэх талаар Тайваний дараа БНСУ удаалж байна. 1980-аад оны дундуур тус улсын засгийн газар экспорт-импорт банкны дэргэд хөгжиж буй орнуудад тусламж үзүүлэх тусгай фонд байгуулжээ. Энэ хүрээнд 1987—1988 онд нийт 150 сая долларын тусламжийг (1991 онд 380 сая долларт хүргэхээр төлөвлөж буй)<sup>7</sup> хөгжиж буй орнуудад зээлийн шугамаар үзүүлсний ихэнхийг АСЕАН-ы орнуудад зориулсан байна. Үүнээс гадна тус улс бүс нутгийн эдийн засгийн байгууллагуудаар дамжуулан тусламж үзүүлдэг бөгөөд 1988 онд «Өмнөд-Өмнөд»-д 200 сая. ЭСКАТО-гийн хамтын ажиллагааны фондод 300 сая<sup>8</sup> доллар олгосон байна.

Шинжлэх ухааны чиглэлтэй үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар БНСУ мөн л Азийн ШҮО-нууд дунд тэргүүн байр эзэлж хувийн болон улс тэрчлэн Шинжлэх ухааны төв байгууллагын хүчин чармайлтыг эрдэм шинжилгээний шинэ эрэл хайгуулын ажилд нэгтгэн хамруулж чиглүүлдэг. зарим тодорхой зорилгод хүрэхийн тулд томоохон пүүс нэгдлүүдийн судалгаа шинжилгээний ажилд зохицуулалт хийдэг, шинжлэх ухаан техникийн дэвшлийг хөхүүлэн дэмжихэд засгийн газар нь идэвхтэй үүрэг гүйцэтгэдэг гол шинжүүдээр шинээр үйлдвэржсэн бусад орноос ялгаатай аж. Гаднаас шинэхэн техник, технологи худалдан авахын зэрэгцээгээр сүүлийн үед үндэсний технологи боловсруулахад анхаарах хандлага нэмэгдэж байна.

Гадаад орны технологийг ашиглах эрх олж авахад зориулж 1961 — 1971 онд 17 сая доллар зарцуулсан бол 1972—1983 онд 813 сая долларт (АНУ-аас 39,4 %, Японоос 32,6 хувь, Өрнөд Европын орнуудаас 28 хувь) хүрчээ.<sup>9</sup>

Энэ бүхнээс үзэхэд БНСУ-ын нөхцөлд өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэл нь боловсруулалт-экспортчилалт-оюуны багтаамж бүхий үйлдвэрлэлт гэсэн үечлэлээр явагджээ гэсэн бүдүүвч харагдаж байна.

---

<sup>1</sup> Международная жизнь. 1989. апрель, Ю. Огнев. Южная Корея с опозданием стр. 101

<sup>2</sup> Танино Сакутаро, Азийн нэгэн бар

<sup>3</sup> Проблемы Дальнего Востока, 90/2. Ю. Столяров, Тихоокеанский регион: тенденции экономического развития, стр. 21

<sup>4</sup> Танино Сакутаро, Азийн нэгэн бар

<sup>5</sup> В. Д. Андрианов «Новые индустриальные страны» в мировом капиталистическом хозяйстве, Москва, 1989, стр. 51-52

<sup>6</sup> ” — стр. 111

<sup>7</sup> ” — стр. 120

<sup>8</sup> ” — стр. 120

<sup>9</sup> ” — стр. 134